ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/118/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг: munkhzayats@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ....3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5**
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6**
**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7**
**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан....8**
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9**
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....10**
3.Аудитын тайлан....11
**3.1 Ерөнхий зүйл....11**
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....11**
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....12**
**3.4 Материаллаг байдал....12**
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....12**
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....12**
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....13**
**3.8 Аудитын гол асуудал....13**
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....13**
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....13**
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....13**
**3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол....14**
4. Аудитын илрүүлэлт....14
**4.1 Залруулсан алдаа....14**
**4.2 Зөвлөмж....14**
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....15

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## 1.Аудитын гэрчилгээ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022. 01.20 № 37

танай ____________-ны №____________-т

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ГАНБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

015030073

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,694,500.00** | **13,041,301.91** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 5,000,000.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 5,000,000.00 | 00.00 |
| **3121** | **Төгрөг** | 5,000,000.00 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 5,000,000.00 | |
| **33** | **АВЛАГА** | | 772,501.91 |
| **335** | **Бусад авлага** | | 772,501.91 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 772,501.91 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 7,694,500.00 | 12,268,800.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,694,500.00 | 12,268,800.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 585,000.00 | 1,370,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,509,500.00 | 5,669,800.00 |
| 35450 | Барилгын засварын материал | | 200,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,600,000.00 | 5,029,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **410,120,024.49** | **458,612,104.72** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 410,120,024.49 | 458,612,104.72 |
| **392** | **Биет хөрөнгө** | 384,124,024.49 | 432,616,104.72 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 298,644,090.00 | 298,644,090.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -20,099,826.96 | -29,195,560.44 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 68,800,000.00 | 68,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,672,222.05 | -30,138,888.65 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,234,836.54 | 113,193,250.54 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -19,618,065.50 | -29,172,786.67 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 55,317,123.76 | 80,423,623.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -34,481,911.30 | -39,937,623.82 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 25,996,000.00 | 25,996,000.00 |
| 39301 | Програм хангамж | 715,000.00 | 715,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -715,000.00 | -715,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,996,000.00 | 25,996,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **422,814,524.49** | **471,653,406.63** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,000,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,000,000.00 | 00.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | 5,000,000.00 | |
| 41430 | Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого | 5,000,000.00 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **417,814,524.49** | **471,653,406.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 417,814,524.49 | 471,653,406.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 245,915,349.75 | 245,915,349.75 |
| 51101 | Өмч: - төрийн | 245,915,349.75 | 245,915,349.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 22,430,661.30 | 76,269,543.44 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 22,430,661.30 | 22,430,661.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 53,838,882.14 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 149,468,513.44 | 149,468,513.44 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **422,814,524.49** | **471,653,406.63** |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **547,064,873.22** | **803,981,114.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **30,870,073.22** | **49,163,914.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 30,870,073.22 | 49,163,914.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 30,870,073.22 | 49,163,914.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 30,870,073.22 | 49,163,914.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **516,194,800.00** | **754,817,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 500,194,800.00 | 744,817,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 500,194,800.00 | 744,817,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,000,000.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,000,000.00 | 10,000,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **536,471,122.91** | **750,142,231.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **536,471,122.91** | **750,142,231.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 533,716,356.21 | 709,841,050.10 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 375,928,385.67 | 440,918,958.60 |
| 210101 | Үндсэн цалин | 368,762,385.67 | 308,140,089.60 |
| 210102 | Нэмэгдэл | | 116,768,670.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,166,000.00 | 16,010,199.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,964,272.63 | 55,734,803.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,935,705.39 | 35,040,390.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,757,141.81 | 7,882,793.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,005,713.45 | 3,434,206.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 751,428.36 | 852,491.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,514,283.62 | 8,524,921.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,791,000.00 | 25,247,607.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,746,880.00 | 3,409,195.58 |
| 210302 | Түлш, халаалт | 8,572,080.00 | 19,603,588.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 272,040.00 | 1,034,824.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,399,856.39 | 29,440,036.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,746,136.00 | 11,360,820.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,305,970.39 | 9,575,356.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,483,700.00 | 2,563,596.23 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 263,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,820,075.00 | 3,091,474.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,843,975.00 | 2,585,090.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 65,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 65,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 28,266,750.00 | 70,216,460.00 |
| 210604 | Урсгал засвар | 28,266,750.00 | 70,216,460.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,000,000.00 | 2,299,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 2,299,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,327,764.00 | 18,212,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,969,864.00 | 16,986,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 698,900.00 | 630,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 70,000.00 | 93,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 198,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 135,000.00 | 260,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,973,327.52 | 67,772,083.77 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 14,788,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,300,000.00 | 17,411,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 31,173,327.52 | 35,572,833.77 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,754,766.71 | 40,301,181.76 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,130,000.00 | 2,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,130,000.00 | 2,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,624,766.71 | 38,301,181.76 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,593,750.31** | **53,838,882.14** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **10,593,750.31** | **53,838,882.14** |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **526,194,800.00** | **754,817,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,000,000.00** | |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,000,000.00 | |
| 120009 | Бусад орлого | 10,000,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **516,194,800.00** | **754,817,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 500,194,800.00 | 744,817,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 500,194,800.00 | 744,817,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,000,000.00 | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,000,000.00 | 10,000,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **515,354,800.00** | **721,937,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **515,354,800.00** | **721,937,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **512,600,033.29** | **681,636,018.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 376,220,957.00 | 441,351,848.60 |
| 210101 | Үндсэн цалин | 274,726,879.00 | 296,854,218.60 |
| 210102 | Нэмэгдэл | 91,420,514.00 | 125,016,848.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,073,564.00 | 19,480,782.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,562,176.29 | 56,074,415.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,749,331.33 | 38,940,951.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,723,662.99 | 4,321,843.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,979,490.39 | 3,434,206.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 714,870.60 | 852,492.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,394,820.98 | 8,524,921.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,791,000.00 | 25,247,607.58 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,746,880.00 | 3,409,195.58 |
| 210302 | Түлш, халаалт | 8,572,080.00 | 19,603,588.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 272,040.00 | 1,034,824.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,130,000.00 | 31,697,896.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,800,000.00 | 11,775,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,330,000.00 | 9,480,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,633,700.00 | 2,944,346.23 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 398,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,600,000.00 | 3,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,566,300.00 | 3,599,850.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 65,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 65,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 31,003,000.00 | 70,905,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,460,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 29,543,000.00 | 70,905,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,000,000.00 | 2,395,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 2,395,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,527,900.00 | 21,164,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,170,000.00 | 19,938,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 698,900.00 | 630,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 70,000.00 | 93,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 198,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 135,000.00 | 260,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,300,000.00 | 32,799,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,000,000.00 | 14,788,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,300,000.00 | 18,011,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,754,766.71** | **40,301,181.76** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,130,000.00 | 2,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,130,000.00 | 2,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,624,766.71 | 38,301,181.76 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,840,000.00** | **32,880,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,840,000.00** | **37,880,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,840,000.00** | **37,880,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,840,000.00 | 37,880,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,840,000.00 | 37,880,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-5,840,000.00** | **-37,880,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 5,000,000.00 | -5,000,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 5,000,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 5,000,000.00 | |

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 245,915,349.75 | 149,468,513.44 | 22,430,661.30 | 00.0 | 417,814,524.49 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 245,915,349.75 | 149,468,513.44 | 22,430,661.30 | 00.0 | 417,814,524.49 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 245,915,349.75 | 149,468,513.44 | 22,430,661.30 | 00.0 | 417,814,524.49 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.0 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 53,838,882.14 | 00.0 | 53,838,882.14 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 245,915,349.75 | 149,468,513.44 | 76,269,543.44 | 00.00 | 471,653,406.63 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 744,817,200.00 | 744,817,200.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 744,817,200.00 | 744,817,200.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 742,817,200.00 | 704,516,018.24 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 474,362,000.00 | 441,351,848.60 |
| 210101 | Үндсэн цалин | 320,562,500.00 | 296,854,218.60 |
| 210102 | Нэмэгдэл | 130,917,100.00 | 125,016,848.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,882,400.00 | 19,480,782.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,745,300.00 | 56,074,415.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,957,200.00 | 38,940,951.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,197,000.00 | 4,321,843.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,357,600.00 | 3,434,206.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 839,400.00 | 852,492.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,394,100.00 | 8,524,921.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,514,000.00 | 25,247,607.58 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,299,200.00 | 3,409,195.58 |
| 210302 | Түлш, халаалт | 20,000,000.00 | 19,603,588.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,014,800.00 | 1,034,824.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,564,200.00 | 31,697,896.23 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,775,000.00 | 11,775,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,480,000.00 | 9,480,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,800,000.00 | 2,944,346.23 |
| 210404 | Ном, хэвлэл | 409,200.00 | 398,700.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,600,000.00 | 3,599,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 107,906,000.00 | 107,905,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,000,000.00 | 17,000,000.00 |
| 210602 | Тавилга | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 70,906,000.00 | 70,905,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,837,000.00 | 2,395,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,837,000.00 | 2,395,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,197,700.00 | 16,164,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,970,000.00 | 14,938,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 630,100.00 | 630,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,600.00 | 93,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 198,000.00 | 198,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 260,000.00 | 260,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23691000.00 | 23679250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,800,000.00 | 4,788,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,891,000.00 | 18,891,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2000000.00 | 2000000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 744,817,200.00 | 744,817,200.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 744,817,200.00 | 744,817,200.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 744,817,200.00 | 744,817,200.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 22.00 | 22.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 09.00 | 09.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **10,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,000,000.00** |

| | | |
|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 10,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10000000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 10000000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас хөдөлмөр хамгааллын хэрэгсэл бэлтгэсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Аудитыг 2022.01.10-аас 2022.01.19–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.01.04-ний өдрийн 59 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Прокурорын байгууллага нь” Прокурорын тухай хуулийн 42.1 дэх заалтаар” Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өвөрхангай аймгийн Прокурорын газрын 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 84.1 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 37.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 46.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авчээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 49.0 сая төгрөгийн материал төсвийн хөрөнгөөр, 2.9 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр бэлтгэж 44.5 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант онд 772.5 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 38.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан улсын төсвөөс 744.8 сая төгрөг авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 10.0 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Прокурорын газар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 144 мэдээллийг ил тод мэдээлсэн, 5 мэдээллийн хугацаа хоцорсон байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд санхүү тайлангийн аудитаар шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан 2 албан шаардлага авсан бөгөөд уг албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1050.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад нийгмийн даатгалын шимтгэл 592.2 мянган төгрөг, ХХОАТ 180.3 мянган төгрөг илүү төлж авлага үүсгээгүй байсныг залруулсан байна.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар.**

1.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас хөдөлмөр хамгааллын хэрэгсэл бэлтгэсэн байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

**Зөвлөмж-1**. Төсвийн тухай хуулийн 22.6.7 төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190-р тогтоолыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх **1** зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад **2022 оны 05 дугаар сарын 01-ний** өдрийн дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Өвөрхангай аймгийн Прокурорын газрын | 1 | 1.77 | 1 | 0.77 | | | | | 1 | 1.0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

2022 ОНЫ 01 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР

**Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт**

**Аудитын нэр:** Санхүүгийн тайлангийн аудит **Аудитын код:** ӨВА-2022/118/НА-СТА-ТШЗ

**Байгууллагын нэр:** Өвөрхангай аймгийн Прокурорын газар

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Урсгал зардал | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас хөдөлмөр хамгааллын хэрэгсэл бэлтгэсэн | 1050.0 | Зөвлөмж өгөх | Санал байхгүй. | Төсвийн тухай хуулийн 22.6.7.төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190-р тогтоолыг мөрдөж ажиллах | Зөвлөмж өгөх | Дарга, Нягтлан бодогч | Т.Ганбат А.Мөнх-Од |

Бэлтгэсэн:

АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ДАРГА Т.ГАНБАТ

НЯГТЛАН БОДОГЧ А.МӨНХ-ОД

ХТҮ2453 6218270878 9044671

**Хавсралт 4**

## Аудитын үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэх маягт

| Аудитын нэр | Санхүүгийн тайлангийн аудит |
|---|---|
| Аудитын код | ӨВА-2022/118/НА-СТА-ТШЗ |

| № | Аудитын үр өгөөжийн товч утга | Санхүүгийн үр өгөөж/ сая төгрөгөөр/ | Санхүүгийн бус үр өгөөж / тоон утгаар/ |
|---|---|---|---|
| 1 | 2021 оны санхүүгийн тайланд авлага дутуу бүртгэсэн | 0,77 | |
| | **Нийт дүн** | **0,77** | |

Шалгагдагч байгууллагын санал:

2021 оны санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэл 592.2 мянган төгрөг, ххаот 180.3 төгрөг илүү төлж авлага үүсгээгүй байсныг санхүүгийн тайлангийн аудитаар авлагаар тусгаж залруулсан.

| | |
|---|---|
| Аудитын үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн:<br><br>Байгууллагын нэр: Аймгийн Прокурорын газар<br><br>ХТҮ2453 6218270878 9044871 | Албан тушаал: Дарга<br><br>Нэр:Т.Ганбат<br><br>Гарын үсэг:<br><br>Огноо: |
| Бэлтгэсэн:<br><br>Аудитор: Ц.Мөнхзаяа<br><br>Огноо:2022.01.17 | Хянасан:<br>Аймгийн Аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: О.Батжаргал<br><br>Аудитын менежер: Д.Гансүх<br><br>Огноо:2022.01.17 |